



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136. Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2018.06.22 № 490

танай _____-ны № _____-г

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Үндэсний аудитын газраас тус төвийн 2017 оны
жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн аудитын
зөвлөмжийн биелэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудас.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.ГАНЦЭЦЭГ

**“Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан**

Огноо 2018/06/21

| № | ҮАГ-ын өгсөн зөвлөмжүүд | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Биелэлт |
|---|---|---|---|
| Асуудал 1. Авлагын талаар | | | |
| 1 | | 2017 оны тоног төхөөрөмж баталгаажуулалтын үйлчилгээний орлого болох 6,517.8 мянган төгрөгийг авлагын тооцооны дансанд бүртгэх. | 2017 оны тоног төхөөрөмж баталгаажуулалтын үйлчилгээний орлого болох 6,517.8 мянган төгрөгийг авлагын тооцооны дансанд бүртгэв. |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу авлага дансанд бүртгэж залруулах. | Тоног төхөөрөмж баталгаажуулалтаас үүссэн 6,517.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах. | Тоног төхөөрөмж баталгаажуулалтын төлбөр төлөөгүй эрүүл мэндийн байгууллагуудад төлбөр барагдуулах тухай албан бичгийг 2018.04.11-ний өдрийн 409-419 тоотой хүргүүлсэн ба Өмнөговь аймгийн БОЭТ авлагаа барагдуулсан. Бусад газрууд тухайн зардлын зүйл ангид мөнгө байхгүй тул төсөвт өөрчлөлт оруулах саналаа ЭМЯ-ны Эдийн засаг, санхүүгийн хэлтэст хүргүүлсэн байна. |
| Асуудал 2. Бараа материалын талаар | | | |
| 3 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх. | Жолоочийн шатахууны тооцоог сар бүр бодон, замын хуудас хөтлөлтөнд хяналт тавин, ажиллана. | 32-94УНЗ, 8142УБЗ, улсын дугаартай 2 автомашины 1-5 сарын шатахууны тооцоог машин тус бүр дээр бодон замын хуудас хөтлөлтөнд хяналт тавин, ажиллаж байна. |
| 4 | Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу авлага дансанд бүртгэж залруулах. | ХНБЗА-ны сургагч багшийн сургалтанд 2017 онд хамрагдсан хүмүүст гэрчилгээг олгож дуусгана. | Хүний нөөцийн бодолого зохицуулалтын албаны зохион байгуулсан “Сургагч багшийн сургалт”-ын гэрчилгээг “Үндэсний үнэт цаас” ХХК-аар хэвлүүлэхээр өгсөн боловч 2017 онд |

| | | | |
|---|---|--|---|
| | | | хэвлэлтээс гарж амжаагүй тул гэрчилгээний төлбөрийг авлагаар бүртгэн, 2018 оны 1-р улиралд гэрчилгээг хүлээн авч сургалтанд хамрагдсан хүмүүст олгов. |
| 5 | Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан бүх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу бүртгэх | 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гарахад бараа материалын данснаас 38 ширхэг 25.7 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 4.1-т заасны дагуу шилжүүлэн бүртгэнэ. | Бараа материалын дансанд бүртгэлтэй 38 ширхэг 25.7 сая төгрөгийн хөрөнгийг 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гарахад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн дансанд тусгах болно. |
| Асуудал 3. Үндсэн хөрөнгийн талаар | | | |
| 6 | Өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарагдах үндсэн хөрөнгийг бүртгэж ажиллах. | ЭМЯ-д ашиглагдаж байгаа студийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх хүсэлтийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт явуулах. | ЭМЯ-д ашиглагдаж байгаа студийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх хүсэлтийг 2018 оны 05 сарын 18-ны өдөр Төвийн захирлын 572 дугаар албан тоотой Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хургуулэв. |
| 7 | | ТӨБЗГазрын шийдвэрийн дагуу ЭМЯ-руу балансаас балансад шилжүүлнэ. | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр ирэхээр балансаас балансад шилжүүлэн бүртгэнэ. |
| Асуудал 4. Зардлын талаар | | | |
| 8 | Төсвийг бодитойгоор зөв төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулах, мөн алдааг давтахгүй ажиллах. | Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэхгүй байхад анхаарна. Шаардлагатай тохиолдолд төсвийн хуваарийн өөрчлөлтийг тухайн сард хийлгэж зардлын ангилал зөрүүлэхгүй ажиллана. | 2018 оны батлагдсан төсвийн хуваарийн дагуу төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. Гэрэл цахилгаан, бичиг хэрэг, мэдээлэл технологи зэрэг зарим нэг зардал хүрэлцэхгүй байсан тул ЭМЯ-ны ЭЗСХ-т төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтээ явуулан, шийдвэрлүүлсэн. |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулах | Бараа материалын дансаар дамжуулалгүй зарцуулсан 13,146.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аван, зарцуулах. | Бараа материалын дансаар дамжуулалгүй зарцуулсан 13,146.7 мянган төгрөгийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн |

| | | | |
|----|---|---|--|
| | | | санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу 2017 оны санхүүгийн тайланд залруулсан. |
| 10 | Сангийн сайдын 2011 оны 132, 188 дугаар тушаалуудыг мөрдөж ажиллах. | Дотоод томилолтыг бодохдоо зочид буудлын төлбөр олгохгүй, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар баталсан тарифын дагуу зам хоног, байрны зардлыг тооцож олгох. | Дотоод томилолтыг бодохдоо Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар баталсан тарифын дагуу байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгож байна. |
| 11 | | Гадаад томилолтын зардлыг бодохдоо Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан тарифын дагуу зам хоног, байрны зардлыг монгол банкны ханшаар тооцож, олгох. | Гадаад томилолтын зардлыг бодохдоо Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан тарифын дагуу зам хоног, байрны зардлыг монгол банкны ханшаар тооцож, олгож байна. |

Хянасан:



Б.Очир /Ахлах нягтлан бодогч/

Боловсруулсан:



С.Лхагвасүрэн /Тооцооны нягтлан бодогч/